



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Ой, хээрийн түймрээс урьдчилан  
сэргийлэх эргүүлийн бүлэг ажиллуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Улсын Онцгой комиссын 2019 оны 01, Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны 02 дугаар, нийслэлийн Онцгой комиссын 2019 оны 02 дугаар албан даалгавруудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Ахмадын хорооны ахмад настнуудаас 12 хүний бүрэлдэхүүнтэй урьдчилан сэргийлэх эргүүлийн бүлгийг Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороо Баянголын аманд 2019 оны 5 дугаар сарын 10-16-ны өдрийг дуустал 6 хоногийн хугацаатайгаар ажиллуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах 360,000 (гурван зуун жаран мянга) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д. Урантулга)-г зөвшөөрсүгэй.

3. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүл хийх ахмад настнуудын зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Урьдчилан сэргийлэх эргүүлийн бүрэлдэхүүний үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг ахмадын хорооны дарга И.Чинбатад үүрэг болгосугай.

ДАРГА,  
ХУРАНДАА



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн  
А/НБ дугаар тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН АХМАДУУДЫГ  
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 1 ДҮГЭЭР ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭР БАЯНГОЛЫН  
АМАНД ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭН НОГООН БҮСИЙН  
ЭРГҮҮЛД АЖИЛЛУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Ахмад настны овог нэр	Тэтгэвэрт гарсан салбар	Нэг хүнд оногдох зардал /төгрөг/
1	Батмөнх Эрдэнэбат	НАА-105	30.000
2	Батбаатар Пүрэвренчин	НОБГ	30.000
3	Жамбалжав Сонгоо	НОБГ	30.000
4	Цэдэв Түмэнбаяр	НОБГ	30.000
5	Дашдорж Чойжилсүрэн	НОБГ	30.000
6	Баваасүрэн Баасанхүү	ГТУА-65	30.000
7	Цагаан Энхцэцэг	ГТУА-11	30.000
8	Бадам Раднаа	ГТУА-26	30.000
9	Цэвээмаа Уламбаяр	ГТУА-26	30.000
10	Наваантуяа Мягмар	ГТУА-10	30.000
11	Жамба Оюунцэцэг	ГТУА-34	30.000
12	Дашдэлэг Эрдэнэтуяа	ГТУА-63	30.000
	НИЙТ ДҮН		360.000